



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ цэнгэг ус" ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: А.Гэрэлмаа

Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	14
4. Аудитын тайлан	15
4.1. Ерөнхий зүйл.....	15
4.2. Материаллаг байдал.....	166
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	16
4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт.....	19
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага.....	21
5.3 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	23



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ААТҮГ-ЫН
ДАРГА А.АЛТАНСҮХ ТАНАА

2025.03.14 № СЭА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй, байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгийн худалдан авалт, санхүү, бүртгэл, тайлагналтад оршиж буй зөрчил материаллаг буюу өргөн хүрээгээр тархсан байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.2.6, ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.7, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтууд болон санхүүгийн

тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал”, “Толилуулга” “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг 1,560,346.5 мянган төгрөгөөр тасалсан, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс татвар, нийгмийн даатгалын өр төлбөр 55,954.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан,
- 268,682.2 мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн цахим баримт болон бусад хүчин төгөлдөр анхан шатны баримтаар баталгаажуулаагүй, төлбөр тооцоог худалдан борлуулсан этгээдийн бус, өөр харилцагчийн дансанд шилжүүлдэг, төлбөрийн цахим баримтыг өөр харилцагчаас авч бүрдүүлдэг зэргээр хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул, санхүүгийн сахилга бат хангалтгүй,
- Байгууллагын харилцах данснаас хувийн хэрэглээний эм, тарианы төлбөрт 2,052.1 мянган төгрөгийг шилжүүлж, байгууллагын нэр дээр төлбөрийн цахим баримт шивүүлж, зардлаар тайлагнасан,
- Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 735,539.4 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,
- Шууд худалдан авах босго үнээс давсан 30,317.5 мянган төгрөгийн нормын хувцас, 99,119.7 мянган төгрөгийн сэлбэг материал, харьцуулалтын аргын босго үнээс давсан 166,719.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авсан,
- Үйл ажиллагааны бус зардал болох татварын хяналт шалгалтаар илэрсэн торгууль, алданги 156,438.0 мянган төгрөг, өмнөх тайлант онуудын өр төлбөрөөс тайланд онд барагдуулсан 224,964.6 мянган төгрөг зэрэг нийт 381,402.6 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаар тайлагнан алдагдлыг нэмэгдүүлсэн,
- Шилэн дансанд мэдээлбэл зохих 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 53,460.0 мянган төгрөгийн “Ус зөөврийн машин”, 141,626.9 мянган төгрөгийн “Бохир усны хуванцар шугам”, Сүхбаатар сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 62,000.0 мянган төгрөгийн “Агаарын машин”, Барилга хот байгуулалтын яамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн 524,894.7 мянган төгрөгийн “Цэвэр усны цайрдсан ган шугам”, аймгийн ОНӨГ-аас 2,037.2 мянган төгрөгийн хурлын ширээ, сандал зэрэг нийт 784,018.8 мянган төгрөгийг хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны орлогыг 4,405,970.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,966,195.6 мянган төгрөгөөр, алдагдлыг 560,225.5 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 2,855,701.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,591,240.7 мянган төгрөгийн зардал гарган, 735,539.4 мянган төгрөгийн алдагдал хүлээж өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,679,746.53	7,477,145.96
1.1.2	Дансны авлага	1,856,719,811.33	2,210,149,866.01
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.01	-
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	275,372,750.65	246,595,708.68
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,243,198.54	2,243,198.54
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,136,015,507.05	2,466,465,919.19
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,509,582,127.88	5,229,229,616.50
1.2.2	Биет бус хөрөнгө	679,545,710.28	676,631,424.30
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,189,127,838.16	5,905,861,040.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,325,143,345.21	8,372,326,959.99
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	53,849,490.41	22,894,220.88
2.1.1.2	Цалингийн өглөг	463,989.22	922,980.44
2.1.1.3	Татварын өр	879,055,594.04	1,458,794,773.71
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,028,493,788.97	1,221,070,046.03
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,961,862,862.64	2,703,682,021.06
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	6,698,800.00	6,698,800.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,698,800.00	6,698,800.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,968,561,662.64	2,710,380,821.06
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Төрийн өмч	1,574,064,600.00	1,574,064,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,161,385,136.32	5,418,270,111.89
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,364,716,091.53	2,148,734,932.11
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,743,584,145.28)	(3,479,123,505.07)
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,356,581,682.57	5,661,946,138.93
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	7,325,143,345.21	8,372,326,959.99

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,963,877,195.62	2,836,473,251.87
2	Борлуулалтын өртөг	2,500,793,163.39	3,510,208,873.33
3	Нийт ашиг (алдагдал)	(536,915,967.77)	(673,735,621.46)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	19,600,545.45	19,228,090.91
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	55,284,440.97	50,598,867.00
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	15,357,826.98	30,432,962.24
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(587,957,690.27)	(735,539,359.79)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(587,957,690.27)	(735,539,359.79)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(587,957,690.27)	(735,539,359.79)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(587,957,690.27)	(735,539,359.79)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	657,289,718.94	(2,155,626,455.01)	10,402,250,121.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	657,289,718.94	(2,155,626,455.01)	10,402,250,121.62
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	707,426,372.59	-	707,426,372.59
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(587,957,690.27)	(587,957,690.27)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(5,165,137,121.37)	-	-	(5,165,137,121.37)
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,574,064,600.00	5,161,385,136.32	1,364,716,091.53	(2,743,584,145.28)	5,356,581,682.57
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.00	5,161,385,136.32	1,364,716,091.53	(2,743,584,145.28)	5,356,581,682.57
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	784,018,840.58	-	784,018,840.58
14	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(735,539,359.79)	(735,539,359.79)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	256,884,975.57	-	-	256,884,975.57
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,574,064,600.00	5,418,270,111.89	2,148,734,932.11	(3,479,123,505.07)	5,661,946,138.93

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,858,650,614.70	2,547,185,610.09
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,837,090,014.70	2,520,808,710.09
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	21,560,600.00	21,150,900.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		5,226,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,762,977,969.62	2,374,669,210.66
1.2.1	Ажиллагсад төлсөн	863,373,443.00	1,172,760,299.30
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	76,485,280.00	122,227,155.94
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	316,214,564.34	344,799,569.82
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	281,681,627.78	442,790,573.92
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	112,909,633.00	133,473,019.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	6,521,360.93	6,161,129.90
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	90,434,233.59	99,545,871.67
1.2.9	Бусад мөнгөн зарлага	15,357,826.98	52,911,591.11
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	95,672,645.08	172,516,399.43
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	115,750,000.00	166,719,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	115,750,000.00	166,719,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(20,077,354.92)	5,797,399.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,757,101.45	1,679,746.53
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,679,746.53	7,477,145.96

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	ОРЛОГЫН ДҮН	м/төг	4,405,970.1	2,855,721.0	(1,550,249.1)	(0.4)
	Үйл ажиллагааны орлого	м/төг	4,384,320.1	2,836,473.3	(1,547,846.8)	(0.4)
	Татаас санхүүжилт	м/төг	21,650.0	19,228.1	(2,421.9)	(0.1)
	Бусад орлого	м/төг	-	19.7	19.7	
2	ЗАРЛАГА ДҮН	м/төг	4,966,195.6	3,591,240.7	(1,374,954.9)	(0.5)
	ЦАЛИН	м/төг	2,352,779.0	1,424,737.3	(928,041.7)	(0.4)
	НД-ийн шимтгэл	м/төг	341,153.0	177,181.9	(163,971.2)	(0.5)
	ҮХ элэгдэл	м/төг	327,506.2	606,426.3	278,920.1	0.9
	Цахилгаан	м/төг	219,313.8	218,243.3	(1,070.5)	(0.0)
	Шатахуун, тээврийн зардал	м/төг	246,494.6	120,948.9	(125,545.7)	(0.5)
	Дулаан	м/төг	263,737.6	202,550.2	(61,187.4)	(0.2)
	Буцалтгүй тусламж	м/төг	25,778.4	6,800.0	(18,978.4)	(0.7)
	Материал	м/төг	86,137.1	171,480.3	85,343.2	1.0
	Үндсэн хөрөнгө худалдан авалт	м/төг	326,000.0	-	(326,000.0)	(1.0)
	Хөдөлмөр хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	м/төг	102,510.0	21,811.4	(80,698.6)	(0.8)
	Холбоо	м/төг	10,583.6	10,684.3	100.7	0.0
	Сургалт	м/төг	16,400.0	12,886.8	(3,513.2)	(0.2)
	Томилолт	м/төг	26,400.0	39,059.7	12,659.7	0.5
	Тээврийн хэрэгслийн татвар	м/төг	1,371.0	598.5	(772.5)	(0.6)
	Үл ХХ-ийн татвар	м/төг	-	27,276.6	27,276.6	-
	НӨАТ, ХАОАТ, суутган	м/төг	383,873.7	373,086.6	(10,787.1)	(0.0)
	Ус ашигласны татвар	м/төг	9,640.0	35,570.7	25,930.7	2.7
	Урсгал засвар	м/төг	100,165.8	9,497.1	(90,668.7)	(0.9)
	Программ хангамжийн зардал	м/төг	11,588.4	11,029.3	(559.1)	(0.0)
	Аудитын зардал	м/төг	3,000.0	3,000.0	-	-
	Даатгал	м/төг	6,400.0	2,250.0	(4,150.0)	(0.6)
	Хүү торгуулийн зардал	м/төг	10,944.0	6,463.3	(4,480.7)	(0.4)
	Зохицуулах үйлчилгээний хөлс	м/төг	9,961.4	24,925.4	14,964.0	1.5
	Харуул хамгаалалтын зардал	м/төг	48,000.0	54,000.0	6,000.0	0.1
	Бусад зардал	м/төг	36,458.0	30,733.0	(5,725.0)	(0.2)
3	Үйл ажиллагааны ашиг алдагдал (1-2)	м/төг	(560,225.5)	(735,519.7)	(175,294.2)	0.1
4	Орлогын татвар (3*10%)	м/төг				
5	ЦЭВЭР АШИГ, АЛДАГДАЛ (3-4)	м/төг	(560,225.5)	(735,519.7)	(175,294.2)	0.1

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь *“Байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно”* гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усан хангамж, ариутгах татуурга,
- Уст цэгийн засвар, өрөмдлөгийн ажил,
- Барилга байгууламжийн засвар үйлчилгээ, гражийн барилга байгууламж,
- Усны хайгуул, судалгаа,
- Халуун ус, саун,
- Гадаад худалдаа гэх мэт.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга байх бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Урсгал ус” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д “*Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно*”, 21 дүгээр зүйл “*Аймгийн чиг үүрэг*”, 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь “*харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “*Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”* гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Нийгмийн даатгалын ерөнхий хууль*

- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 08 дугаар сарын 30-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч, борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, татаас санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, дахин үнэлгээ дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,679.7	7,477.1	5,797.4
Авлага	1,856,719.8	2,210,149.9	353,430.1
Татвар, НДШ-ийн авлага			-

Бараа материал	275,372.8	246,595.7	(28,777.1)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,243.2	2,243.2	-
Үндсэн хөрөнгө	5,189,127.8	5,905,861.0	716,733.2
Нийт хөрөнгийн дүн	7,325,143.3	8,372,326.9	1,047,183.6
Өр төлбөр	1,968,561.7	2,710,380.8	741,819.1
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,161,385.1	5,418,270.1	256,885.0
Эздийн өмч	195,196.5	243,676.0	48,479.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,325,143.3	8,372,326.9	1,047,183.6

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7,477.1 мянган төгрөг болж 5,797.4 мянган төгрөгөөр өссөн нь 2,625,230.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 2,619,432.8 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 2,210,149.9 мянган төгрөг болж 353,430.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн нэгж болон оршин суугчдаас авах үйлчилгээний төлбөрийн авлага өссөнөөс голлон шалтгаалсан байна.

Нийт авлагын 70.1 хувийг буюу 1,548,358.4 мянган төгрөгийг байгууллага, аж ахуйн нэгжээс авах усны, 14.3 хувийг буюу 316,787.9 мянган төгрөгийг айл өрхөөс авах усны, 9.6 хувийг буюу 212,945.9 мянган төгрөгийг байгууллагаас авах, 3.9 хувийг буюу 85,513.6 мянган төгрөгийг ажилчдаас авах буюу дараа тайлангийн, 1.0 хувийг буюу 23,159.0 мянган төгрөгийг хувь хүнээс авах, 1.1 хувийг буюу 23,385.1 мянган төгрөгийг цалингийн авлага эзэлж байна.

Байгууллага, аж ахуйн нэгжээс авах 1,548,358.4 мянган төгрөгийн усны авлагын 87.2 хувийг эзэлж буй Сэлэнгэ энерго ААТҮГ-с авах усны авлага 1,350,922.2 мянган төгрөгийг барагдуулж чадахгүй байгаа нь мөнгөн хөрөнгийн эргэлт, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж байгаа тул 2024 онд өр, авлага бууруулах ажлын хүрээнд тус газраас авах авлагыг барагдуулахаар Сэлэнгэ аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 148/1032024/02429 захирамжийн дагуу эвлэрлийн гэрээг баталгаажуулан 2029 оны 4-р сарыг дуустал сар бүр системтэйгээр барагдуулахаар харилцан тохиролцож, гэрээ байгуулан ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 246,595.7 мянган төгрөг болж 28,777.1 мянган төгрөгөөр буурсан нь 357,579.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 386,356.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,905,861.0 мянган төгрөг болж 716,733.2 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалжээ. Үүнд:

- Өөрийн хөрөнгөөр 166,719.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан,
- Аймгийн ОНӨГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,037.2 мянган төгрөгийн хурлын ширээ, сандлыг шилжүүлэн авсан,

- Аймгийн хөрөнгө оруулалтаар 53,460.0 мянган төгрөгийн ус зөөврийн машин, 141,626.9 мянган төгрөгийн бохир усны хуванцар шугам үнэ төлбөргүйгээр хүлээн авсан,
- Сүхбаатар сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 62,000.0 мянган төгрөгийн 2 ширхэг агаарын машин үнэ төлбөргүйгээр хүлээн авсан,
- Барилга хот байгуулалтын яамны хөрөнгө оруулалтаар хийгдсэн 524,894.7 мянган төгрөгийн цэвэр усны цайрдсан ган шугам үнэ төлбөргүйгээр хүлээн авсан,
- Үлдэх өртөггүй 372,421.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэн,
- Тайлант онд 606,426.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс тус тус шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,710,380.8 мянган төгрөг болж 741,819.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татварын болон НДШ-ийн өр төлбөрийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Нийт өр төлбөрийн 53.8 хувийг буюу 1,458,794.8 мянган төгрөгийг татварын, 45.1 хувийг буюу 1,221,070.0 мянган төгрөгийг НДШ-ийн, 0.5 хувийг буюу 12,400.6 мянган төгрөгийг айл өрхөд өгөх усны өглөг буюу урьдчилж орсон орлого, 0.3 хувийг буюу 8,117.8 мянган төгрөгийг байгууллагад өгөх бараа үйлчилгээний өглөг, 0.2 хувийг буюу 6,698.8 мянган төгрөгийг урт хугацаат өр төлбөр, 0.1 хувийг буюу 3,298.8 мянган төгрөгийг цалингийн болон хувь хүмүүст өгөх өр төлбөр эзэлж байна.

2023 онд тус байгууллагад татварын хяналт шалгалтаар ногдуулсан татвар, торгууль, алдангийн 156,438.0 мянган төгрөгийг тайлант онд бүртгэсэн нь өр төлбөр өсөхөд нөлөөлсөн байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй. “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж Сэлэнгэ аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Тайлант оны орлогыг 4,405,970.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,4966,195.6 мянган төгрөгөөр, алдагдлыг 560,225.5 мянган төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 2,855,701.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,591,240.7 мянган төгрөгийн зардал гарган, 735,539.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого 2,855,701.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөгөө 35.0 хувиар тасарсан нь цэвэр усны үнэ тарифыг 6 сараас

нэмэгдүүлэх, шинээр худаг өрөмдлөгийн орлогын төлөвлөгөө баталсан боловч үнэ тариф нэмэгдээгүй, худаг өрөмдлөгийн төхөөрөмж нь газрын хөрснөөс шалтгаалан өрөмдөх үйлчилгээ тасалдсан зэргээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардал 3,591,240.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан нь нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой үйл ажиллагааны бус зардал болох татварын хяналт шалгалтаар илэрсэн торгууль, алданги 156,438.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаар тайлагнасан, зохицуулах үйлчилгээний хөлс 14,964.0 мянган төгрөгөөр, элэгдлийн зардал төлөвлөснөөс 278,920.1 мянган төгрөгөөр, томилолтын зардал 12,659.7 мянган төгрөгөөр тус тус хэтэрч, бусад зардлууд хэмнэгдсэнээс шалтгаалан нийт төлөвлөсөн зардлыг 27.7 хувиар хэмнэсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гүйцэтгэсэн болон үндсэн хөрөнгийн ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,571,435.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 38,571.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь мэдээлбэл зохих 26 төрлийн 157 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

Хугацаа хоцроож мэдээлсэн:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт - 3 удаа,
- Санхүүгийн тайлан – 1 удаа,
- Дараа жилийн зорилтот түвшин- 1 удаа,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө – 1 удаа,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан- 1 удаа,
- Байгууллагын батлагдсан төсөв – 1 удаа гэх мэт.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Цэнгэг ус ААТҮГ нь шатахууны худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Шатахуун	119,773.4	119,773.4	НТШ
	Нийт дүн	119,773.4	119,773.4	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг худалдан авах ажиллагааны цахим системд 2 удаа байршуулан зарласан боловч оролцогч ирээгүйн улмаас “Ник петровис” ХХК-тай шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан 30,317.5 мянган төгрөгийн нормын хувцас, 99,119.7 мянган төгрөгийн сэлбэг материал, харьцуулалтын аргын босго үнээс давсан 166,719.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр “Хүүгийн гутал” ХХК, “Оргилуун ундарга нуур” ХХК, “Нишин илч” ХХК, “Таванхан” ХХК, “Зандо электроникс” ХХК-уудаас шууд худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг”, 2: “Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-100.0 сая төгрөг” заалтыг зөрчсөн байна.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,092,012.9 мянган төгрөгөөр,
- Дулааны зардлыг 61,187.4 мянган төгрөгөөр,
- Шатахууны зардлыг 125,545.7 мянган төгрөгөөр,
- Даатгалын зардлыг 4,150.0 мянган төгрөгөөр,
- Урсгал засварын зардлыг 90,668.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/64 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 996,531.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 1,595.3 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон зөрчилд 1 төлбөрийн акт, 912,780.5 мянган төгрөгийн төлөвлөсөн орлогыг дутуу төвлөрүүлсэн, өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй 3 зөрчилд албан шаардлага, 82,155.6 мянган төгрөгийн нотлох дэмжих баримтгүй хоолны зардал гаргасан, үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн, шилэн данстай холбоотой 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 57.1 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,595.3	1	1,595.3	100.0
Албан шаардлага	3	912,780.5	1	912,780.5	33.3
Зөвлөмж	3	82,155.6	2	82,155.6	66.6
Нийт дүн	7	996,531.4	4	996,531.4	57.1

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал:

- Үндсэн орон тоонд батлагдсан эдийн засагчийн ажлын байрыг хавсран гүйцэтгүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлт үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг үнэн зөв төлөвлөж батлуулахгүй байгаа нь өр, авлага, алдагдал, зардлын өсөлтөд нөлөөлж ашигт ажиллагаа, төлбөрийн чадварыг бууруулж байна.
- Санхүүгийн ажилтнуудын орон тоо, бүтцийн дагуу орон тоог бүрдүүлэн ажиллуулаагүйгээс ерөнхий нягтлан бодогч Г.Сувд нь эдийн засагч, цалин, хөлс, нийгмийн даатгалын нягтлан бодогчийн ажил зэргээр 3 ажлын байрыг, зураг төсөл горим тооцооны инженер Н.Мягмар нь мөнгөн хөрөнгийн болон материалын нярвын зэрэг 3 орон тоог, тооцооны нягтлан бодогч Д.Батчулуун нь борлуулалтын менежерийн ажлыг, ХАБЭА-н инженер Б.Тэгшжаргал нь хүний нөөцийн менежерийн ажлыг, бичиг хэргийн ажилтан Д.Солонго нь архивын ажлыг тус тус хавсран гүйцэтгэж байна.

Цаашид шаардлагатай ажлын байранд мэргэжлийн мэдлэг бүхий ажилтанг орон тооны дагуу ажиллуулах, онцын шаардлагагүй хавсран гүйцэтгэж буй орон тоог цөөлж нэгтгэн зардал хэмнэх зэргээр бүтэц, орон тоонд өөрчлөлт хийн зохион байгуулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **35,794.5** мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд 12,354.9 мянган төгрөгийн худаг өрөмдлөгийн орлогыг илүү, 23,440.5 мянган төгрөгийн усны орлогыг дутуу тайлагнасан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулаагүй алдаа:

1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 397,856.6 мянган төгрөгийн залруулаагүй алдаа илэрлээ.

- Зардлыг үнэн зөв ангилан бүртгэдэггүй, татварын ногдлыг тухайн тайлант онд нь үүсгэн өр төлбөрөөр бүртгэхгүй байгаа зэргээс тайлант онд үйл ажиллагааны бус зардал болох татварын хяналт шалгалтаар илэрсэн торгууль, алданги 156,438.0 мянган төгрөг, өмнөх онуудын өр төлбөрөөс тайланд онд барагдуулсан 224,964.6 мянган төгрөг зэрэг нийт 381,402.6 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаар тайлагнан алдагдлыг нэмэгдүүлсэн,

- 16,454.0 мянган төгрөгийн цахилгаан үүсгүүр, инвертер, процессор, тень зэрэг тоног төхөөрөмжийг НӨАТ төлөгч байгууллагаас худалдан авсан боловч НӨАТ салгалгүй нийт дүнгээр орлого авч бүртгэсэн,

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1: “*тухайн татварын тайлант хугацаанд хамарсан байх*”, 13.1.2: “*албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх*”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт Гуравдугаар бүлгийн (а) дахь “*орлогын дэлгэрэнгүй тайланг бэлтгэхдээ тухайн тайлант үед хамрагдах орлого, зардлын ажил гүйлгээг аккруэл зарчмаар бүртгэнэ*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант үетэй холбоотой үйл ажиллагааны зардлыг үнэн зөв тодорхойлох, НӨАТ-тай холбоотой бичилтийг санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлж байх зөвлөмж хүргүүлэх.

Аудитаар нийт **1,887,035.0** мянган төгрөгийн 7 зөрчил¹ илрүүлснээс 2,052.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,884,982.9 мянган төгрөгийн зөрчилд 3, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын харилцах данснаас хувийн хэрэглээний эм, тарианы үнэ болох 2,052.1 мянган төгрөгийг шилжүүлж, байгууллагын нэр дээр төлбөрийн цахим баримт шивүүлж, зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6: “*Сахилга баттай байх*”, 4.2.6: “*Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хувийн хэрэглээний эм, тарианы үнийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс боловсруулж, батлуулсан 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд орлогыг 4,405,970.1 мянган төгрөг байхаар төлөвлөсөн боловч 2,845,623.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг **1,560,346.5** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалт болон аймгийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Засаг даргын баталсан "Сэлэнгэ цэнгэг ус" ААТҮГ-ын "2024 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, төлөвлөгөөг биелүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант хугацааны эцэст татвар болон нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд татварын өр төлбөр 54,043.6 мянган төгрөгөөр дутуу, нийгмийн даатгалын өр төлбөр 1,910.6 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...”*, *“20.2.7: “Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, ...”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж, төлбөрийн үлдэгдлийг тулган баталгаажуулсны үндсэн дээр авлага, өр төлбөрийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант онд худалдан авалтын анхан шатны баримт бүрдүүлэлт, санхүү, нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ: Үүнд:

- 54,000.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын ажил үйлчилгээ, 96,212.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.
- Худалдан авсан 118,470.0 мянган төгрөгийн трансформатор, насос, хаалт зэрэг сэлбэг, төхөөрөмжийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй, төлбөр тооцоог худалдан борлуулсан этгээдийн бус, өөр харилцагчийн дансанд шилжүүлдэг, төлбөрийн цахим баримтыг өөр харилцагчаас авч бүрдүүлдэг зэргээр хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул, санхүүгийн сахилга бат хангалтгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь *“Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг борлуулагчийн цахим баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг ханган, борлуулагчийн дансанд төлбөр тооцоог хийсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчлийг давтан гаргасан, холбогдох албан тушаалтнууд албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, ...ыг хугацаанд нь биелүүлээгүй ..., санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу дарга А.Алтансүх, ерөнхий нягтлан бодогч Г.Сувд нарт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Хуримтлагдсан ашиг, алдагдал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 735,539.4 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй бөгөөд үйл ажиллагаа явуулах тусам алдагдлын хэмжээ нэмэгдэж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Тус газрын үйл ажиллагаанд санхүүгийн шинжилгээ хийж, өөрийгөө санхүүжүүлэн ажиллах.

2. Авлага, өр төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 2,210,149.9 мянган төгрөгийн авлага, 2,710,380.8 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна. Авлага, өр төлбөрийг үр дүнд нөлөөлөхүйцээр барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжүүлээгүйгээс он дамжсан авлага, өр төлбөр тайлагнагдаж, төлбөрийн чадвар, эдийн засгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж, байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “*Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,...*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлага, өр төлбөрт дүн шинжилгээ хийж бууруулах үр нөлөө бүхий арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтад тусгасны

дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Борлуулалтын орлогыг илүү, дутуу тайлагнасан	1	35,794.5			1	35,794.5	1	35,794.5				
Зардал илүү тайлагнасан	1	381,402.6			1	381,402.6			1	381,402.6	1	381,402.6
Үндсэн хөрөнгийг НӨАТ салгалгүй бүртгэсэн	1	16,454.0			1	16,454.0			1	16,454.0	1	16,454.0
Дүн	3	433,651.1			3	433,651.1	1	35,794.5	2	397,856.6	2	397,856.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хувийн хэрэглээний эм тарианы төлбөрийг шилжүүлж, зардлаар тайлагнасан	1	2,052.1	1	2,052.1								
Санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг тасалсан	1	1,560,346.5			1	1,560,346.5						
Өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй	1	55,954.2			1	55,954.2						
Өөрөө өөрийгөө санхүүжүүлж ажиллаж чадаагүй	1	-					1	-				
Авлага, өр төлбөрийг бууруулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй	1	-					1	-				
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримт болон	1	268,682.2			1	268,682.2						

бусад бүрдэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан												
Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэсэн, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлсэн захирал, ерөнхий нягтлан бодогч нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх								1	2			
Дүн	7	1,887,035.0	1	2,052.1	3	1,884.982.9	2	-	1	2		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг 8 удаа хоцроосон	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Нийт дүн	2				2			